

	A	B	C	D	E	F	G	H
1	Он	2011						
2								
3			<b>2011</b>					
4								
5			1-р сар					
6		Да	Мя	Лх	Пү	Ба	Бя	Ня
8	52						1	2
9	1	3	4	5	6	7	8	9
10	2	10	11	12	13	14	15	16
11	3	17	18	19	20	21	22	23
12	4	24	25	26	27	28	29	30
13	5	31						
14								

Зураг 19. Эпидемиологийн 7 хоногийг тодорхойлох

л. ТТӨ, 10000 - аймгуудийн ТТӨ-ний 10000 хүн ам дахь өвчлөлийг өмнөх 7 хоног мөн өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулж харуулна

м. Лаб, Аймаг - илэрсэн вирусийг аймгаар харуулна

Эпидемиологийн 7 хоногийг тодорхойлох

Мэдээ оруулахдаа голдуу алдаг зүйл бол эпидемиологийн долоо хоногийг тодорхойлох байдаг.

Үүнийг олон улсад тогтоосон журмаар (дэлгэрэнгүйг [http://en.wikipedia.org/wiki/ISO\\_8601](http://en.wikipedia.org/wiki/ISO_8601) хаягаар орж үзнэ үү) тооцохийн тулд <http://www.flu.mn/mgl/calendar.xls> хаягаар орж "calendar.xls" файлыг татаж авч долоо хоногийг тооцно. Программыг ашиглахдаа

1. "calendar.xls" файлыг нээнэ,
2. "Он" хэсэгт оноо оруулж компьютерийн гаран дээрээс "Enter" товчийг дарна. Ингэхэд тухайн оны календарь гарна. Эхний багана долоо хоногийн тоо[Зураг 19].

\* \* \*

## АУДИО ХУРАЛ ХИЙХ ЖУРАМ

Л.Энхбаатар, П.Нямдаваа

Монгол-АНУ-ын "Томуу тандалтын сүлжээ бэхжүүлэн хөгжүүлэх" төслийн баг

2010 оноос интертэд суурилсан томуугийн мэдээллийн систем (ИСТМС)-ийг нэвтрүүлж эхлэхэд гарч байсан бэрхшээл бодит хугацаанд шийдвэрлэх үүднээс намайг төслийн баг Skype тогтолцоог ажилгаа ТХТН-үүдтэй аудио-хурал зохион байгуулж эхэлсэн

билээ. Цаашид бид энэ аудио-хурлаа үргэлжлүүлэх, бусад халдварт өвчний тандалт, дархлаажуулалын ажлын явцыг энэ тогтолцоогоор харилцан мэдээлж байх журамд шилжих зорилт тавьж байгаа юм.

### Хурлын дэг

1. Аудио хурлыг Skype messenger ашиглаж явуулна.
2. Хурал эхлэхээс 10 минутын өмнө ТХТН-үүд Skype -д орсон байна.
3. ТХТН-үүд хуралдааны өөрийн талын оролцогчдын ахлагчийг сонгосон байна.
4. Хурлын явцад оролцогчид мэдээлэл хийх, асуулт, хариулт өгөхөөс бусад үед микрофоноо **mute** эсвэл **off** горимд байлгана.
5. ТҮТ-ийн хурал даргалагч хурлыг нээж хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулна.

6. ТҮТ-ийн хурал даргалагч ТҮТ-өөс оролцогчдыг танилцуулсны дараа ТХТН-үүдээс оролцогчид хурал даргалагчийн асуусан дарааллаар өөрийн болон бусад оролцогчдын нэр албан тушаалыг танилцуулна.

7. Дүүргүүдэд ЭМН, НЭ, аймгуудад ЭМГ, НЭ-үүд, Өрхийн эмнэлгийн төлөөлөл нэг газраас холбогдоно.

8. Мэдээлэл хийх, асуух, хариулах, буюу санал хэлэхдээ ярьж буй хүнийг дуустал хүлээгээд дараа нь өөрийнхөө нэр, албан тушаалаа хэлж, товч бөгөөд тодорхой ярина. Ярьж дуусаад “**МИНИЙ ХЭЛЭХ ЮМ ДУУСЛАА**”, “**АСУУЛТ ДУУСЛАА**” гэж мэдэгдэнэ.

9. Ярьж буй хүн микрофонд ойртож 5 см-ээс холгүй зайтай ярих ба ярьж байхдаа микрофонд хүрэхгүй байх шаардлагатай.

10. Техникийн шалтгаанаас болж тасалдал гарсан тохиолдолд ТҮТ-ийн дата менежер/вэб мастер Б. Ганцоожтой утсаар холбогдож (утас: 91998239) эргэн холбогдоно.

11. Асуулт, танилцуулгаа хурлын явцад *Skype messenger*-ийн **share, send file** командыг ашиглан мэдээлж болно.

2011-2012 оны томуугийн улиралд баримтлахаар санал болгож буй хурлын хэлэлцэх асуудлын үлгэрчилсэн төлөвлөгөө дэг, хуваарийг Хүснэгт 1 ба 2-оос үзнэ үү.

Хэлэлцэх асуудлын үлгэрчилсэн төлөвлөгөө

Хүснэгт 1

Хэлэлцэх асуудал	Хариуцах	Хугацаа
Оролцогсдын бүртгэл, танилцуулга	Л.Энхбаатар	10 минут
Ингэрнэтэд суурилсан тандалтын мэдээллийн систем (ИСТМС)-ийг ашиглаж Томуугийн харуулдан тандалтын нэгж (ТХТН)-үүдийн мэдээ өгсөн байдал	Б.Ганцоож	10 минут
ТТӨ-ий өвчлөлийн байдал, цаг үеийн мэдээлэл	А.Бурмаа	10 минут
Холбогдсон ТХТН-үүдээс ирүүлсэн болон өмнөх 7 хоногт ирсэн сорьцонд лабораторийн шинжилгээ хийсэн тухай мэдээлэл	Б.Дармаа	10 минут
ТХТН-үүдээс асуулт асуух, санал хэлэх	оролцогчид	Хүн бүр 3 минут хүртэл
Дүгнэлт	Л.Энхбаатар	5 минут

2011-2012 оны Томуугийн Улиралад ТХТН-үүдтэй аудио хурал хийх хуваарь

Хүснэгт 2

№	Оролцох аймаг, сум хот дүүрэг	Сар бүрийн 1-р долоо хоног	Сар бүрийн 2-р долоо хоног	Сар бүрийн 3-р долоо хоног	Сар бүрийн 4-р долоо хоног	ТХТН-үүдээс оролцох мэргэжилтнүүд	Түүт-өөс оролцох мэргэжилтнүүд
1	Улаанбаатар хотын амбулаторид суурилсан (өрхийн эмнэлгүүд) 23 нэгж	Лхагва гаригт, 13.00-14.00 цагт				Өрхийн эмч, бусад эмч сувиллагч нар	А.Бурмаа, Б.Дармаа, Л.Энхбаатар, Б.Ганцоож, Ц.Оюунчимэг
2	Улаанбаатар хотын эмнэлэгт суурилсан тандалтын нэгжүүд (лавлагаа төв, дүүргийн ЭМН, НЭ 22 нэгж)	Лхагва гаригт, 14.00-15.00 цагт				Лавлагаа төвийн тандалтын багийн ахлагч, дүүргийн ЭМН, НЭ-ийн халдвар судлагч, дүн бүртгэгч эмч, бусад эмч, сувиллагч нар	А.Бурмаа, Б.Дармаа, Л.Энхбаатар, Б.Ганцоож, Ц.Оюунчимэг
3	Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Өмнөговь, Төв, Говь-Сүмбэр, Дорноговь		Лхагва гаригт, 14.00-15.00 цагт				А.Бурмаа, Б.Дармаа, Л.Энхбаатар, Б.Ганцоож, Ц.Оюунчимэг
4	Булган, Орхон, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Дархан-Уул, Сэлэнгэ			14.00-15.00 цагт		Аймгийн ЭМГ, НЭ-ийн халдвар судлагч, дүн бүртгэгч эмч, бусад өрхийн эмнэлгийн төлөөлөгчид	А.Бурмаа, Б.Дармаа, Л.Энхбаатар, Б.Ганцоож, Ц.Оюунчимэг
5	Ховд, Баян-өлгий, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор				14.00-15.00 цагт	Аймгийн ЭМГ, НЭ-ийн халдвар судлагч, дүн бүртгэгч эмч, бусад өрхийн эмнэлгийн төлөөлөгчид	А.Бурмаа, Б.Дармаа, Л.Энхбаатар, Б.Ганцоож, Ц.Оюунчимэг

Жич: Өвчлөл ихэссэн, дэгдэлт гарсан үед энэ хуваарийг урьдчилан тохиролцоод өөрчилж болно.